

Хилийн заставын эрлийн ажиллагааг оновчтой зохион байгуулж явуулах нь

Улсын хилийг зөрчилгүй, тайван байлгах гол нөхцөл нь хоногийн хугацаанд тасралтгүй хяналт, хамгаалалттай байж, улмаар хилийн зөрчил гарсан тохиолдолд түргэн шуурхай, цаг алдалгүй саатуулах ажиллагаа байдаг. Иймд заставын дарга хилийн зөрчил гарахаас өмнө харилцан ажиллагаатай байгууллагын хүчийг нэгтгэн харилцан ажиллах журмыг тодотгон зохион байгуулж удирдана.

Хилийн эрлийн ажиллагааны эхлэл буюу бэлтгэл нь хил зөрчигчийг эрэх саатуулах урьдчилсан ажиллагааны төлөвлөгөөг оновчтой зөв боловсруулах явдал мөн. Өнөөгийн нөхцөлд хил зөрчигчид албаны амьтад болон өндөр хурдтай техник ашиглан аль болох дөт замаар улсын хилд ойртон үйл ажиллагаагаа явуулж байгааг анхаарч заставын даргаас ХЗГБЧ-ийг өвөл-зун, өдөр-шөнө, дотоод – гадаадаас гэсэн хувилбар бодомжоор төлөвлөн түүнийг хоногийн шилжилтийн ямарч үед ажиллах журам, тооцоо судалгаа, дадлагыг хийж, улиралд нэгээс доошгүй эрлийн сургуулийг явуулах нь зүйтэй. Хилийн эрлийг явуулахдаа заставын газар орны онцлог, цаг агаарын байдал, улирлын өөрчлөлт, өнгөлөн далдлах боломж, орон нутгийн ард иргэдийн байршил зэргийг харгалзан үзнэ.

Хилийн зөрчил гарсан тухай мэдээ авмагц заставын даргын ажиллах журам нь:

- Шийдвэрийг оновчтой цаг алдалгүй гаргах ба гэнэт ажиллах,
- Бага хүчээр богино хугацаанд эрлийг идэвхитэй тасралтгүй явуулах,
- Хүч хэрэгслийг богино хугацаанд шилжүүлэн байрлуулж, чадварлаг зохион байгуулах явдал юм.

Түүнчлэн хилчдийн дадлага сургалт, бие бялдарын болон сэтгэл зүйн бэлтгэлийг өндөр түвшинд байлгаж, сахилга зохион байгуулалтыг чанд сахих нь үүссэн цагийн байдалтай уялдуулан хүч хэрэгслийг нягт харилцан ажиллуулж, цаг хугацааг хэмнэх зэрэг олон талын ая холбогдолтой байдаг. Эндээс хилийн дугаар отрядад гэмт хэрэг үйлдээд оргон зугтаасан байлдагч М.Хатансүхийг эрж,

ХИЛ СУДЛАЛ

саатуулсан ажиллагаа хэрхэн болсныг авч үзье. Эрлийн ажиллагаанд тус отрядын офицер, ахлагч 23 хүн оролцжээ.

Ололттой тал нь:

- Гэмт хэрэг гарсан тухай мэдээллийг отряд хүлээн аваад оператив бүлэг, эмнэлгийг арван минутад гаргасан нь дараагийн ажиллагаанд шилжихэд их дөхөмтэй болсон.

- Орон нутагт отор хийж байсан айлуудыг халдлагаас сэргийлж хамгаалалтад авч чадсан.

- Эрлийн заагуудыг нарийвчлан тогтоож, хүч хэрэгслээ төвлөрүүлж дараагийн шатанд ажиллах журмаа тогтоож байсан нь үр дүнгээ өгсөн.

- Эрэх бүлгүүд гэмт этгээдийн хаяж гэсэн зүйл, бие зассан байдлаар нь түүний явсан чиглэл, өнгөрсөн хугацаа, мөрийг зөв тодорхойлж чадсан.

- Эрлийн ажиллагаанд цагдаагийн байгууллага, орон нутгийн ард иргэдийн хүчийг сайн ашиглаж ажилласан.

Дутагдалтай тал:

- Гэмт этгээдийн хурдыг цагт 5 км явна гэж тооцоолж түүний хаалтыг тавьсан боловч цагт 8 км-ийн хурдтай явснаар хаалтын цаана гарсан байсан.

- Эрлийн үед холбооны хэрэгсэл байхгүйгээс бүлгүүд хоорондоо амаар хашгирч харьцаж байсан нь гэмт этгээдэд дараагийн ажиллагаанд шилжих нөхцөлийг бүрдүүлж өгсөн.

- Эрлийн явцад офицер, ахлагч нарын сэтгэл зүйн бэлтгэл дутуу байсан нь өвөлжөөний амбаар нэгжих, үзлэг хийх явцад илэрч, түүнд орж чадахгүй, эсвэл ямар ч хамгаалалтгүй орж амь насаа алдах аюулд өртөж болзошгүй байв.

- Эрэх бүлэг, хаалт манаанд туршлагатай, газар орноо сайн мэддэг офицеруудыг томилоогүйн улмаас эрэл удааширч, гэмт этгээд хаалтын гадна үлдсэн, хяналтыг муу зохион байгуулсан зэрэг алдаа илэрсэн.

- Заставууд хил талаа цаг алдаж хааснаар хэрвээ гэмт этгээд хилийн зүг явсан тохиолдолд алдах боломжтой байсан зэрэг дутагдлууд гарчээ гэж үзэж байна.

Энэхүү эрлийн ажиллагааны онцлог шинж нь:

1. Зэвсэглэсэн гэмт этгээдийг эрэх явцад бүх гуу жалга, нуугдаж болзошгүй газар орныг бүслэн түүнд дөхөж очин, нэг бүрчлэн үзлэг шалгалт хийж байсан нь эрэл их удаан явагдахад хүргэсэн.

2. Эрэлд оролцож буй офицер, ахлагч нарын нэг нь ул мөр хайж, газарт үзлэг хийж явахад нөгөө хэсэг нь алсын бараа харж, гэмт этгээдийн зэвсэг хэрэглэх болон нуугдаж болзошгүй газар руу хяналт тавьж заавал бие биенээ хамгаалж явах шаардлагатай байсан.

3. Эрлийн үед машин, тээврийн хэрэгслийг зогсоох шаардлага гарвал заавал хамгаалалтад авч байсан.

4. Хилийн заставыг дахин халдлагаас сэргийлж, мэргэн буудагчийг ойр орчимд байрлуулсан зэрэг онцлогтой байв.

Үүнээс үндэслэн дараах дүгнэлтийг хийж болох байна:

- Сургалтын хөтөлбөрт алан хядах ажиллагаатай тэмцэх тактик ажиллагааг оруулах

- Хил хамгаалалт, хилийн эрэлд нэг бүрийн болон олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгслээр хангах, бие бүрэлдэхүүнийг сургаж дадлагажуулах

- Офицер, ахлагч нарын сургалтыг чанаржуулж тэдний сэтгэл зүйн бэлтгэлийг хангах

- Гэмт этгээд, бэлтгэгдсэн хил зөрчигчийн хурдыг дахин хянаж үзэх зэрэг болно.

*ХЦДС-ийн Хилийн албаны тэнхимийн багш
дэд хурандаа Ж.Өвгөнбүргэд*